

ТАНИЛЦУУЛГА

“Журам, гэрээний загвар, төлбөрийн хэмжээ батлах тухай” Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалын төслийн талаар

Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг тус тус баталж, мөн оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам, мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээний загвар, сургалтын болон нотариатч улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан ашигласны төлбөрийн хэмжээг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасны дагуу “Журам, гэрээний загвар, төлбөрийн хэмжээ батлах тухай” Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалын төслийг боловсрууллаа.

Тушаалын төслийн 1 дэх заалтаар “Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам” болон “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээний загвар”-ыг батлахаар, 2 дахь заалтаар нотариатч улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан ашигласны төлбөрийн хэмжээг нэг жилд 50000 /тавин мянган/ төгрөг байхаар тогтоохоор тусгасан бөгөөд энэ тушаалыг 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр юм.

“Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам”-ын төсөл 5 бүлэг, 20 заалттай.

Журмын төсөлд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ байгуулсан нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд зуучилж мэдүүлэг, түүнд хавсаргасан баримт бичгийг цахим мэдээллийн санд илгээх, улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангаас мэдүүлэг гаргагчийн тухайн мэдүүлэгтэй холбогдох үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийг авч, эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд зуучлахад ашиглах, иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлөөр хуульд заасны дагуу нотариатчаар дамжуулан авах мэдээллийг цахим мэдээллийн сангаас тухайн иргэн, хуулийн этгээдэд гаргаж өгөхтэй холбогдсон ажиллагааг тусгасан.

Нотариатчид цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээх, уг эрхийг цуцлах асуудлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр шийдвэрэлэнэ.

Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаатай холбогдсон сургалтыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулах бөгөөд уг сургалттай холбогдсон зардлыг Монголын нотариатчдын танхим хариуцахаар төсөлд тусгасан.

Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл нийлүүлэх гэрээг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан Монголын нотариатчдын танхимын гишүүн, нотариатчтай түүний Улсын бүртгэлийн ерөнхий газарт гаргасан хүсэлтийг үндэслэн байгуулна.

Гэрээний төсөлд уг гэрээгээр нотариатч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх, хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлөөр тухайн иргэн, хуулийн этгээдийн холбогдох мэдээллийг улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангаас авахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, гэрээг нэг жилийн хугацаагаар байгуулахаар тусгаснаас гадна гэрээний талуудын эрх, үүрэг, цахим мэдээллийн сангаас мэдээлэл авах, ашиглах, түүний аюулгүй байдал, найдвартай ажмиллагааг хангах үйл ажиллагааны журам, гэрээг дуусгавар болгох, цуцлах нөхцөл, журам, мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам зөрчсөнөөс учирсан хохирлыг шийдвэрлэх журмыг тусгасан.

“Журам, гэрээний загвар, төлбөрийн хэмжээ батлах тухай” Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалын төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль зэрэг хуулийн зохицуулалтад нийцүүлэн боловсруулсан болно.

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам, гэрээний загвар, төлбөрийн хэмжээ батлах тухай

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам”-ыг 1 дүгээр, “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээний загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Нотариатч улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан ашигласны төлбөрийн хэмжээг нэг жилд 50000 /тавин мянган/ төгрөг байхаар тогтоосугай.

3.Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар /Б.Баасандорж/, Монголын Нотариатчдын танхим /Р.Онончимэг/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Билгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны
... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

НОТАРИАТЧИЙН МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ байгуулсан нотариатч /цаашид “нотариатч” гэх/ эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх, уг сангаас мэдээлэл авах үйл ажиллагаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Нотариатын тухай хууль болон энэ журмыг баримтална.

1.2.Нотариатч улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан /цаашид “цахим мэдээллийн сан” гэх/-д үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл /цаашид “эрхийн улсын бүртгэл” гэх/-тэй холбогдуулан мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авахад дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

1.2.1.мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд зуучилж мэдүүлэг, түүнд хавсаргасан баримт бичгийг цахим мэдээллийн санд илгээх;

1.2.2.цахим мэдээллийн сангаас мэдүүлэг гаргагчийн тухайн мэдүүлэгтэй холбогдох үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийг авч, эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд зуучлахад ашиглах;

1.2.3.иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлөөр хуульд заасны дагуу нотариатчаар дамжуулан авах мэдээллийг цахим мэдээллийн сангаас тухайн иргэн, хуулийн этгээдэд гаргаж өгөх.

Хоёр.Мэдээлэл нийлүүлэх

2.1.Нотариатч энэ журмын 1.2.1-д заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд зуучлахад дараах ажиллагааг хийнэ:

2.1.1.мэдүүлэг гаргагчийн нотлох баримт бичгийг шалгах, шаардлагатай тохиолдолд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрлөөр цахим мэдээллийн сангийн холбогдох мэдээллийг шалгах;

2.1.2.мэдүүлэгт хавсаргах баримт бичгийг шалгаж хуульд нийцүүлэх;

2.1.3.цахим мэдээллийн санд мэдүүлгийг бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөн цахим гарын үсгээр баталгаажуулан илгээх;

2.1.4.мэдүүлэг гаргагч улсын бүртгэлийн байгууллагад баримт бичгийн эх хувийг хүргүүлэх тохиолдолд мэдүүлэг гаргагчид мэдүүлгийг илгээсэн тухай баримтыг энэ журмын 2.1.2-т заасан баримт бичгийн хамт хүлээлгэн өгөх;

2.1.5.нотариатч улсын бүртгэлийн байгууллагад баримт бичгийн эх хувийг хүргэх тохиолдолд мэдүүлэгт хавсаргасан баримт бичгийн эх хувийг хүлээн авсан талаарх баримтыг мэдүүлэг гаргагчид өгөх.

2.2.Улсын бүртгэгч нотариатчаар зуучлуулан цахим хэлбэрээр гаргасан мэдүүлэгт хавсаргасан нотлох баримтын бүрдлийг хянаж, эрхийн улсын бүртгэлд бүртгэх тухай, эсхүл мэдүүлэг хүлээн авахаас татгалзах тухай мэдэгдлийг нотариатчид илгээнэ.

Гурав.Мэдээлэл авах

3.1.Нотариатчид цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр нээнэ.

3.2.Нотариатчийн цахим мэдээллийн санд нэвтрэх эрх энэ журмын 1.1-д заасан гэрээний хугацаанд хүчинтэй байна.

3.3.Нотариатч мэдүүлэг гаргагчийн зөвшөөрлөөр тухайн мэдүүлэгт хамаарах хуульд заасны дагуу нотариатчаар дамжуулан авах мэдээллийг цахим мэдээллийн сангаас авч, эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд зуучлахад ашиглана.

3.4.Нотариатч иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр цахим мэдээллийн сангаас тухайн иргэн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг өөрт нь гаргаж өгч болно.

Дөрөв.Цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлах

4.1.Нотариатчийн цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр дараах тохиолдолд цуцална:

4.1.1.гэрээ дуусгавар болсон;

4.1.2.хуульд заасан бусад.

Тав.Бусад

5.1.Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаатай холбогдсон сургалтыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

5.2.Энэ журмын 5.1-д заасан сургалттай холбогдсон зардлыг Монголын нотариатчдын танхим хариуцна.

5.3.Нотариатч цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг бусдад шилжүүлэх, цахим мэдээллийн сангийн мэдээллийг хуульд зааснаас бусад зорилгоор ашиглах, бусдад ашиглуулах, шилжүүлэхийг хориглоно.

5.4.Энэ журмыг зөрчсөн нотариатчид холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны
... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

БАТЛАВ.
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ

БАТЛАВ.
МОНГОЛЫН НОТАРИАТЧДЫН

/Гарын үсэг/

/Нэр/

/Гарын үсэг/

/Нэр/

МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ ГЭРЭЭ

... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан Монголын нотариатчдын танхимын гишүүн, _____ дүүргийн тойргийн нотариатч /... дугаар тамгатай/ _____ /эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр/-ын ... оны ... дугаар сарын ...-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт гаргасан хүсэлтийг үндэслэн:

Нэг талаас: Улсын бүртгэлийн ерөнхий газар, түүнийг төлөөлж Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга _____ /эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр/, Мэдээллийн технологийн газрын дарга _____ /эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр/;

Нөгөө талаас: Монголын нотариатчдын танхимын гишүүн, _____ дүүргийн тойргийн нотариатч _____ /эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр/ /цаашид “нотариатч” гэх/ нар /цаашид “талууд” гэх/ Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож, энэ “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ” /цаашид “гэрээ” гэх/-г байгуулав.

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэ гэрээгээр нотариатч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх, хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлөөр тухайн иргэн, хуулийн этгээдийн холбогдох мэдээллийг улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан /цаашид “цахим мэдээллийн сан” гэх/-аас авахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2.Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг хууль, журмаар зохицуулна.

Хоёр.Гэрээний хугацаа

2.1.Энэ гэрээний хугацаа ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс ... оны ... дугаар сарын ...-ны өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.

2.2.Нотариатч гэрээний 2.1-д заасан хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө гэрээг дахин байгуулах хүсэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бичгээр гаргаж болно.

2.3.Гэрээ цуцлах тухай саналыг аль нэг тал гаргах тохиолдолд 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд талууд төлбөр тооцоо, үйл ажиллагааг харилцан дүгнэж, гэрээг дуусгавар болгоно.

Гурав.Улсын бүртгэлийн мэдээллийн сан ашигласны төлбөр, тооцоо

3.1.Цахим мэдээллийн санг ашигласны 1 /нэг/ жилийн төлбөр нь 50000 /тавин мянган/ төгрөг байна.

3.2.Нотариатч нь гэрээний 3.1-д заасан төлбөрийг гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газрын _____ банкны _____ дугаар дансанд шилжүүлнэ.

3.3.Энэ гэрээг цуцалсан тохиолдолд гэрээний 3.2-т заасан төлбөрийг буцаан олгохгүй.

Дөрөв.Талуудын эрх, үүрэг

4.1.Улсын бүртгэлийн ерөнхий газар дараах эрхтэй:

4.1.1.мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг нотариатчаас шаардах;

4.1.2.нотариатч гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээг цуцлах;

4.1.3.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нотариатчаас шаардах;

4.1.4.нотариатчийн үйл ажиллагаа хууль, журам, гэрээнд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих.

4.2.Улсын бүртгэлийн ерөнхий газар дараах үүрэгтэй:

4.2.1.нотариатчийн холбогдох цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээх;

4.2.2.нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэх;

4.2.3.сургалт зохион байгуулах.

4.3.Нотариатч дараах эрхтэй:

4.3.1.холбогдох цахим мэдээллийн санд нэвтрэх эрх нээлгэх;

4.3.2.мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт гаргах.

4.4.Нотариатч дараах үүрэгтэй:

4.4.1.мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны хүрээнд олж авсан мэдээллийг хууль, журам, гэрээнд заасны дагуу ашиглах;

4.4.2.хуульд заасан шаардлагыг хангаж ажиллах;

4.4.3.хуульд заасан шаардлага хангасан техник хэрэгсэл, программ хангамж ашиглан мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв, бүрэн гүйцэд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд оруулах;

4.4.4.мэдүүлгийг илгээхдээ цахим гарын үсгээр баталгаажуулах;

4.4.5.мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулах сургалтад хамрагдах.

Тав.Цахим мэдээллийн сангаас мэдээлэл авах, ашиглах, түүний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах үйл ажиллагааны журам

5.1.Нотариатч мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаанд хамаарах хууль, журмыг мөрдөж, мэдээллийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангаж ажиллана.

5.2.Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны хүрээнд олж авсан мэдээллийг бусдад тараах, дамжуулах, шилжүүлэх, хуульд зааснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Зургаа.Гэрээг дуусгавар болгох, цуцлах нөхцөл, журам

6.1.Дараах үндэслэлээр гэрээг дуусгавар болгоно:

6.1.1.гэрээний хугацаа дууссан;

6.1.2.талуудын санаачилгаар гэрээг цуцалсан;

6.1.3.улсын бүртгэлийн байгууллагын бүтцэд өөрчлөлт орсны улмаас гэрээг шинэчлэн байгуулах нөхцөл үүссэн;

6.1.4.нотариатчийн харьяалах тойрог өөрчлөгдсөн.

6.2.Дараах үндэслэлээр гэрээг цуцална:

6.2.1.нотариатчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын санаачилгаар;

6.2.2.нотариатч улсын бүртгэлийн мэдээллийн сан ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлээгүй бол Улсын бүртгэлийн ерөнхий газрын санаачилгаар;

6.2.3.гэрээг цуцлах талаар нотариатчийн бичгээр гаргасан саналаар.

**Долоо.Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам
зөрчсөнөөс бусдад учирсан хохирлыг шийдвэрлэх журам**

7.1.Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаанд хамаарах хууль, журам, гэрээг зөрчсөний улмаас бусдад учирсан хохирол, нөхөн төлбөрийг барагдуулах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

Найм.Бусад зүйл

8.1.Талууд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

8.2.Гэрээг хоёр хувь үйлдэх ба талууд тус бүр нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**Улсын бүртгэлийн ерөнхий газрыг
төлөөлж:**

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ДАРГА

/Нэр, гарын үсэг, тамга/

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА

/Нэр, гарын үсэг, тамга/

ДҮҮРГИЙН
ТОЙРГИЙН НОТАРИАТЧ
/... дугаар тамгатай/

/Нэр, гарын үсэг, тамга/

Хаяг: _____

Утас: _____

---oOo---